

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/143/14-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
4.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ
ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ГАНТӨГС
ТАНАА

2019.03.15 № 06/469
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайланг хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Гантөгс Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Тэд-Аудит” ХХК-ийн аудитор Г.Эрдэнэчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/11 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлыг олон улсын зангилаа болгон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 150 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн Монголын талд ногдох 49 хувийг эзэмших “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулж, дүрмийг батлахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.

Уг тогтоолоор “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Зам, тээврийн хөгжлийн яам 66.0 хувь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг 34.0 хувиар тус тус томилсон бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг баталж, 7 дугаар сарын 03-ны өдөр хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн 000167456 тоот гэрчилгээ авч байгуулагджээ.

Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

- “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент” төслийг хэрэгжүүлэх Япон, Монголын хамтарсан хуулийн этгээдийн Монгол Улсын төрийн мэдлийн 49 хувийн хувьцааг эзэмшигчийн эрх үүргийг компанийн тухай хууль, компанийн дүрэм болон холбогдох гэрээний хүрээнд хэрэгжүүлэх;
- Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын төрийн үйлчилгээний Хүндэт зочны танхим /586 кв.м/-ын үйл ажиллагааг эрхлэх;
- Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал дахь агаарын хөлгийн ангарын болон бусад барилга байгууламжийн менежментийг хэрэгжүүлэх;
- Хамтарсан компанид ашиглуулахаас бусад нисэх буудлын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;
- Тусгай хэрэгцээний газрыг хувьцаа эзэмшигчээс эрх олгосноор газар ашиглах гэрээ байгуулах;
- Өөрийн болон хамтарсан компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, хамааралгүй нисэх буудлын үйл ажиллагааны чиглэлээр бизнесийн болон менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Хамтарсан компанийн үйл ажиллагаанд хамааралгүй “Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудал”-ын бусад үйл ажиллагаанд чиглэгдэж байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан “...компани нь тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө байх” гэсэн заалтын дагуу эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагааны үр дүнд орлого олж түүгээрээ санхүүжиж ашигтай ажиллах ёстой.

Гэтэл тайлант жилд өөрийн үйл ажиллагаанаас олох орлогын эх үүсвэр байхгүй, Иргэний нисэхийн ерөнхий газраас урсгал зардлыг нь санхүүжүүлж, баланс тайлан нь алдагдалтай гарсан байдлаас харахад хуулийн дагуу ажиллаж чадаагүй байна.

Нөгөө талаас ИНЕГ нь Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1-д зааснаар “Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бөгөөд үйл ажиллагаа нь Мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэж заасан байна. Одоогийн байдлаар өөрийн дүрэмд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хэлбэрээр, мөн олсон орлогоороо өөрийгөө санхүүжүүлэх төрийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн хэлбэр бүхий хоёрдмол статустай үйл ажиллагаа явуулж байна.

ИНЕГ-т 2000-2008 онуудад хэрэгжүүлсэн Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй хамтран “Монголын Иргэний нисэхийн Мастер төлөвлөгөө боловсруулах (MONCAMP) төсөл”, Иргэний нисэхийн салбарын бодлогыг боловсруулах төсөл”, Тусгай туслалцааны төслийн баг (SAPROF) NUBIA төслийн хүрээнд хийсэн судалгаагаар өгсөн зөвлөмжүүд болон Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 1.2.3. “Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын зөвлөмжийн дагуу иргэний нисэхийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг хангахуйц бүтцийн шинэчлэл хийх, 1.2.6. нисэх буудлуудын дэд бүтцийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх; 2.1.3. “Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтцийг тухайн салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн олон улсын жишгээр өөрчлөн зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэсэн зөвлөмжүүдийг удаа дараа өгсөн байна.

Эндээс үзэхэд дээрх Олон улсын төсөл хөтөлбөрүүд, гэрээ, зөвлөмжүүдийн гол утга санаа нь ИНЕГ-ын гол чиг үүрэг болох мэргэжлийн хяналт, зохицуулалтыг бодлого,

үйлчилгээнээс нь салгах, харин илүү үр ашиг, үр өгөөжтэй арилжааны чиглэлийн байгууллага болгох зорилгоор дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоонд өөрчлөлт оруулах, мөн Агаарын навигацийн болон Нисэх буудлын үйлчилгээг нэгтгэл болгох асуудлыг авч үзэх, хувийн хэвшлийн оролцоог түлхүү ашиглах саналууд, Иргэний нисэх дэх арилжааны шинж чанартай бүхий л төрлийн үйлчилгээнээс татгалзах, ингэснээр тэдгээр үйлчилгээний хэлбэрүүд нь хувийн хэвшлийн оролцооны хувьд нээлттэй болж үүний үр дүнд үйлчилгээг олон нийтэд нээлттэй хүргэх, хэрэгжүүлэх хариуцлага нь хувийн хэвшлийн компаниудад шилжих тухай санал зөвлөмжүүд байна.

Иймд дээрх Олон улсын санал санаачлага, зөвлөмжүүдтэй уялдуулан 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд тус компанийн үйл ажиллагааны эрхэм зорилгод нийцүүлэн чиг үүрэг, хөрөнгө нөөц бололцоог нэмэгдүүлэх болон оновчтой бүтэц, зохион байгуулалтад оруулах талаар холбогдох дээд байгууллагын төлөөлөлд шийдвэр гаргуулах нь зүйтэй.

Цаашид тус компанийн эрх зүйн байдлыг тодорхой болгосноор эд хөрөнгийн эх үүсвэр баталгаажиж, үр өгөөжтэй, зөв оновчтой бүтэц зохион байгуулалтад орж, компанийн засаглал сайжирч, компанийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж өгөх болно гэж аудит үзэж байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив” програм хангамж ашиглаж байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын дүнгээс 1 хувиар сонгов.

2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь АОУС 320-ын дагуу тодорхойлсонтой холбоотой юм.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны үйл ажиллагааны нийт зардал 173.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь байгууллагын хамрах хүрээ хязгаарлагдмал, санхүүжилтийн хэмжээ бага, өөрийн орлого байхгүй, гарч болох эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцон зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	0.00	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилласан байдал, тус компанийн хууль эрх зүйн талаар авсан арга хэмжээний талаар дахин хянаж үзнэ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 03 тоот тогтоолоор тус компанийн 2018 оны үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нийт 540.3 сая төгрөгөөр баталсан. Тайлант жилд гүйцэтгэлээр 408.2 сая төгрөгийг зарцуулж тайлант жилийн эцэст харилцах дансанд 132.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 322 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд шаардагдах 17.1 сая ам.доллартай тэнцэх 42.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017, 2018 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос санхүүжүүлэхийг Зам, тээвэр, хөгжлийн сайд, Сангийн сайдад даалгасны дагуу эхний ээлжийн санхүүжилт болох 27.1 тэрбум төгрөгийг тус компанийн Капитрон банкны 3096002184 тоот дансанд байршуулжээ.

Тайлант жилд тус компани орлогын дэлгэрэнгүй тайлангаар хүүгийн орлогоор нийт 9.2 сая төгрөг олж, урсгал зардалд 172.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант жилд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг буюу шилэн дансны цахим хуудсаар мэдээлж байгаа боловч компанийн байранд олон нийтэд ил тод харагдахаар мэдээллийн самбар байршуулдаггүй.

Тус компанийн шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 150 дугаар тогтоолоор 2018 оны 07 дугаар сарын 02-нд дүрмийг нь баталж, 7 дугаар сарын 03-ны өдөр хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн 000167456 тоот гэрчилгээ авч байгуулагдсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС, СТОУС болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн удирдлага нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт (НББОУС 8)-ыг зөрчиж байна.

Энэ нь Үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт (НББОУС 8) тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй, холбогдох хууль дүрэм, журам, стандарт зөрчсөн байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт (НББОУС 8)-ын дагуу өөрийн үйл ажиллагааны онцлогт уялдуулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант жилд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсаар мэдээлж байгаа боловч компанийн байранд олон нийтэд ил тод харагдахаар мэдээллийн самбар байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 1.1, 5.7, 5.8 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Энэ нь Үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 1.1, 5.7, 5.8 дахь заалт тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		27,235,099,343.36
1.1.2	Дансны авлага		34,999.99
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		214,229.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн		27,235,348,572.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		227,838,151.05
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		227,838,151.05
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		27,463,186,723.40
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		5,647.62
2.1.1.3	Татварын өр		629,770.85
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		635,418.47
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		635,418.47
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		1,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		27,625,446,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг		-163,894,695.07
2.3.11	Эздийн өмчийн дүн		27,462,551,304.93
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		27,463,186,723.40

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
3	Нийт ашиг (алдагдал)		
5	Хүүгийн орлого		7,780,127.21
8	Бусад орлого		1,511,464.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал		172,408,273.57
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		-163,116,682.36
19	Орлогын татварын зардал		778.012.71
20	Татварын дараах ашиг (алдагдал)		-163,894,695.07
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-163,894,695.07
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн		-163,894,695.07
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,000,000.00			1,000,000.00
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-163,894,695.07	-163,894,695.07
3	Өмчид гарсан өөрчлөлт		27,625,446,000.00		27,625,446,000.00
4	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	27,625,446,000.00	-163,894,695.07	27,462,551,304.93

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		27,626,596,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		27,626,446,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		150,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		163,584,463.85
1.2.1	Ажиллагчдад төлсөн		87,699,450.54
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		21,861,708.90
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		5,242,232.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		23,498,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		2,475,435.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		9,654,548.03
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		180,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага		12,973,089.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		27,463,011,536.15
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		7,780,127.21
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		7,780,127.21
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		235,692,320.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		235,692,320.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-227,912,192.79
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		27,235,099,343.36
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,235,099,343.36

5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.12	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
				САГ-2019/143/14-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тус төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн удирдлага нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт (НББОУС 8)-ыг зөрчиж байна	0	Зөвлөмж өгсөн	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	М.Гантөгс Б.Ганбат
2	Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант жилд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсаар мэдээлж байгаа боловч компанийн байранд олон нийтэд ил тод харагдахаар байрлуулсан мэдээллийн самбар байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 1.1, 5.7, 5.8 дахь заалтуудыг зөрчиж байна	0	Зөвлөмж өгсөн	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	М.Гантөгс Б.Ганбат
	Дүн	0			

